



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/90

Улаанбаатар хот

### Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1082 дугаар захирамж, Газрын дүрмийн 2.5.3, 3.1.2, 3.1.9 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилго бүхий “Талын түмэн адуу” арга хэмжээний хүрээнд хотын аялал жуулчлал, хот орчмын өвлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлахаар ирсэн БНХАУ-ын хэвлэл мэдээллийн ажилтнууд, гэрэл зурагчдын багийг Улаанбаатар хотод ажиллахад дэмжлэг үзүүлэн ажиллахыг Мэдээлэл сурталчилгааны хэлтэс /Д.Жавхлан/-т даалгасугай.

2. БНХАУ-ын хэвлэл мэдээллийн ажилтнууд, гэрэл зурагчдаас бүрдсэн багийг Улаанбаатар хотод ажиллах нөхцөлөөр хангахад шаардагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. БНХАУ-ын хэвлэл мэдээллийн ажилтнууд, гэрэл зурагчдаас бүрдсэн багийг Улаанбаатар хотод ажиллах нөхцөлөөр хангахад шаардагдах хөрөнгө болох 3,618,000 /гурван сая зургаан зуун арван найман мянга / төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Нягтлан бодогч /Б.Батцоож/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА *D. Batsum* Д.БАТСҮХ



1150500325

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 11  
сарын 19 өдрийн А/90 дугаар  
тушаалын хавсралт

524025 GET 48936 1118263502

БНХАУ-ЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БОЛОН ГЭРЭЛ ЗУРАГЧДААС БҮРДСЭН  
БАГИЙГ УЛААНБААТАР ХОТОД АЖИЛЛАХ НӨХЦӨЛӨӨР ХАНГАХАД  
ШААРДАГДАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

2018 оны 11 дүгээр сарын 19

Улаанбаатар хот

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Зочид буудал	5 хүн	5 хоног	70 000	1 750 000
2	Зочдын хоол	10 удаа	5 хоног	25 000	1 250 000
3	Загвар өмсөгч, Фото зургийн төхөөрөмж түрээс	1 хүн	1 хоног	618 000	618 000
НИЙТ ДҮН:					3 618 000